



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 388

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар дахин худалдах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дахь заалт, , “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 7,382,270 (долоон сая гурван зуун наян хоёр мянга хоёр зуун далан) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу 475,000.00 (дөрвөн зуун далан таван мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Н.Алтантуяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
 288 дугаар тогтоолын хавсралт

Говь-Алтай аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, дахин
 нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	ТӨБЭГ-ын 2017 оны 526 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Худалдах доод үнэ шинэчлэн тогтоосон /төгрөг/
1	Уаз фургон, 7811 ГАА арал- 10053308, хөдөлгүүр-0007370	2000/2000	37520	7,382,270.00	500,000.00	475,000.00
				7,382,270.00	500,000.00	475,000.00
	Нийт дүн			7,382,270 (Долоон сая гурван зуун наян хоёр мянга хоёр зуун далан)	500,000.00 (таван зуун мянган)	475,000.00 (дөрвөн зуун далан таван мянган)